НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 09 өдөр Дугаар А/128 Улаанбаатар хот

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр "Телекамер дэд хөтөлбөр, замын хөдөлгөөний удирдлагын систем"-ийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Гантулга)-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

1110200632

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 03-ны өдрийн
А/128 тушаал захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2023 ОНД "ТЕЛЕКАМЕР ДЭД ХӨТӨЛБӨР, ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН СИСТЕМ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүд болон угсралт суурилуулалт /Баянгол дүүрэг/	2020	2023	1,086.2	32.1
3	Авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүд болон угсралт суурилуулалт /Хан-Уул дүүрэг/	2020	2023	471.6	471.6
2	Авто замын хөдөлгөөн зохицуулалт, бүртгэл, зөрчил илрүүлэх камер, дагалдах тоног төхөөрөмжүүд болон угсралт суурилуулалт /Баянзүрх дүүрэг/	2020	2024	1,036.8	36.7
ДҮН				2,594.6	540.4